

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 03 ДУГААР САРЫН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2024 оны 04 дугаар сарын 09

Улаанбаатар хот

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор байгууллагын үйл ажиллагааны 03 дугаар сарын биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын 38 арга хэмжээг хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Нийт арга хэмжээний 81.5 хувь нь үр дүнтэй буюу 100 хувь, 16.05 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-90 хувьтай үнэлэгдсэн байна. (График 1, Хүснэгт 1)

График 1



Хүснэгт 1

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний зорилт, хэрэгжилтийн үнэлгээ /хувиар/						Хувь	
	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн			Эрчимжүүлэх шаардлагатай		Үр дүнгүй	Дундаж хувь
		100%	90%	70%	50%	30%		
1	2	3	4	5	6	7	8	
38	31	6	1	-	-	-	97.6	

Зорилт тус бүрээр ангилан авч үзвэл Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд “Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ” арга хэмжээнд тусгагдсан ажлууд үр дүнтэй буюу 100 хувиар, Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна”, Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд “Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна”, Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд

“Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ” арга хэмжээнд тусгагдсан ажил тодорхой үр дүнд хүрсэн буюу 97.7, 90, 97.7 хувиар тус тус үнэлэгдсэн. (Хүснэгт 2)

Хүснэгт 2

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	0-30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна	1	-	1	-	-	-	90
2	Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна	9	7	2	-	-	-	97.7
3	Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ	27	23	3	1	-	-	97.7
4	Инновацад суурилсан цахим шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлнэ	1	1	-	-	-	-	100
Нийт		38	31	6	1	-	-	96.3

Чиглэл тус бүрээр авч үзвэл Иргэний харьяаллын газар, Зөрчил шалган шийдвэрлэх газар, Санхүүгийн хэлтэс, Хангалт, үйлчилгээний хэлтсүүдийн хэрэгжүүлсэн арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 100 хувиар үнэлэгдсэн. Харин үнэлгээ буурсан арга хэмжээнд:

- Захиргаа, удирдлагын газар: Зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан боловч хугацаандаа шийдвэрлээгүй-1, тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу үр дүн гарах болоогүй-1, нийт 2 арга хэмжээ;
- Виз, зөвшөөрлийн газар: Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан-2, нийт 2 арга хэмжээ;
- Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс: Зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан-1, нийт 1 арга хэмжээ;
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс: Зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан-1, нийт 1 арга хэмжээ;
- Мэдээллийн технологийн хэлтэс: Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй 1, нийт 1 арга хэмжээ байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	30%	0%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Захиргаа, удирдлагын газар	13	11	1	1	-	-	96.9
2	Виз, зөвшөөрлийн газар	3	1	2	-	-	-	93.3
3	Иргэний харьяаллын газар	3	3	-	-	-	-	100
4	Зөрчил шалган шийдвэрлэх газар	3	3	-	-	-	-	100
5	Санхүүгийн хэлтэс	3	3	-	-	-	-	100
6	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс	4	3	1	-	-	-	97.5
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс	3	2	1	-	-	-	96.6
8	Мэдээллийн технологийн хэлтэс	2	1	1	-	-	-	95
9	Хангалт, үйлчилгээний хэлтэс	1	1	-	-	-	-	100
10	Захиргаа, удирдлагын газар, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс	1	1	-	-	-	-	100
11	Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	1	-	-	-	-	100
12	Санхүүгийн хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	1	-	-	-	-	100
Нийт		38	31	6	1	-	-	98.2

Мөн газар, хэлтсүүдийн буюу Захиргаа, удирдлагын газар, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс хамтарсан 1, Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1, Санхүүгийн хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1, нийт 3 арга хэмжээ 100 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Дүгнэлт, зөвлөмж

Байгууллагын 2024 оны 03 дугаар сард төлөвлөн гүйцэтгэсэн 38 арга хэмжээний хэрэгжилт 97.6 хувьтай үнэлэгдлээ. Цаашид дараах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай. Үүнд:

1. “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70 хувьтай үнэлэгдсэн 1 арга хэмжээ

Арга хэмжээ (20): Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалт зохион байгуулах

- Захиргаа, удирдлагын газар шалгуур үзүүлэлт, зорилтод түвшинг тодорхой төлөвлөж гүйцэтгэх;

“Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 90 хувьтай үнэлэгдсэн 8 арга хэмжээ

Арга хэмжээ (1) “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системийг сайжруулах

- Мэдээллийн технологийн хэлтэс тус арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаж, системийн үйл ажиллагааг жигдрүүлэх;

Арга хэмжээ (2): Гадаадын иргэнд олгох Монгол Улсын виз, зөвшөөрлийн үйлчилгээг зохион байгуулах

- Виз, зөвшөөрлийн газар гадаадын иргэнд олгох Монгол Улсын виз, зөвшөөрлийн үйлчилгээний чанарыг сайжруулах;

Арга хэмжээ (2): Гадаадын иргэний бүртгэл, хяналтыг эрхлэх

- Виз, зөвшөөрлийн газар гадаадын иргэний бүртгэл, хяналтыг эрхлэхдээ үнэн бодит, мэдээллээр хангаж, үйлчилгээг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээг бүрэн авч ажиллах;

Арга хэмжээ (12): Азийн хөгжлийн банкны төлөөлөгчидтэй албан уулзалт зохион байгуулах

- Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс зорилтод түвшинд хүрч байгууллагын танилцуулгыг хийх;

Арга хэмжээ (25): Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шуурхай шийдвэрлүүлэх

- Захиргаа, удирдлагын газар байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг бүртгэж, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах;

Арга хэмжээ (32): Гадаадын иргэний бүртгэл, хяналтын сарын статистик мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх

- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс гадаадын иргэний бүртгэл, хяналтын мэдээг бэлтгэхдээ үнэн бодит мэдээллийг холбогдох нэгжүүдээс гаргуулан авч, хугацаанд нь дээд шатны байгууллагад хүргүүлж уялдаа холбоог сайжруулах;

3. “Үр дүнтэй” буюу 100 хувьтай үнэлэгдсэн 31 арга хэмжээний үр дүнг цаашид бууруулахгүйгээр чанаржуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.